



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 23 өдөр

Дугаар 146

Дэлгэрхаан сум

Эзэмших газрын талбайн хэмжээ
өөрчлөх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын 1.9.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх ажил хэрэгжсэнтэй газрын хэмжээ өөрчлөгдсөн Натул хязгаарлагдмал хувьцаат компанид 4702 кв.м газрыг 39 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2005 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 71 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж, гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг Натул хязгаарлагдмал хувьцаат компаний захирал (Х.Туяа) үүрэг болгосугай.

4. Натул хязгаарлагдмал хувьцаат компанид газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэн олгож, гэрээ байгуулан, биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын даамал (Ч.Батзориг)-т даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2326010292

